

“Японы менежмент, жижиг дунд үйлдвэр: хөгжлийн туршлага”

/Тод бичиг хэвлэлийн компани, УБ. 2014, 10,0 х.х./ хамтын бүтээл

ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн Япон судлалын секторт гүйцэтгэсэн “Монгол Улсын хөгжлийн стратеги бодлогыг хэрэгжүүлэхэд Японы хөгжлийн туршлагын хүчин зүйл (Японы менежмент, жижиг дунд үйлдвэрийн бодлого, хүний хөгжлийн бодлогын туршлагын жишээгээр)” сэдэвт ажлын судалгааны үр дүнд олон нийтийн хүртээл болж буй энэхүү хамтын бүтээл нь японы менежментийн хөгжил тухайлан аж үйлдвэрийн соёл, удирдлагын арга барилын талаар мөн Япон улсад жижиг дунд үйлдвэрийн бодлогыг эдийн засаг, нийгмийн хөгжлийн үе шат бүрийн онцлогт нийцүүлэн, ард түмний аж амьдралыг дээшлүүлэхэд гүйцэтгэх үүргийг чухалчлан үзсэний үндсэн дээр системтэйгээр боловсруулан хэрэгжүүлж ирсэн туршлага, жижиг дунд үйлдвэрийн эдийн засагт эзэлж буй байр суурь, өнөөгийн байдал зэргийг судлан танилцуулах зорилт тавьсан болно. Мөн Япон улсын хүний хөгжлийн бодлогын зарим хэсэг, тухайлбал залуу үеийг хөгжүүлэх үзэл баримтлалыг боловсролын бодлого, сургалтын хөтөлбөрт хэрхэн тусгаж, хэрэгжүүлж ирсэн туршлагаас танилцуулахыг зорилоо.

Энэ номын “Япон маягийн менежмент, туршлага” хэмээх I бүлгийн I зүйлийг магистр Т.Амгалан, II зүйлийг магистр У.Загдцэсэм, III зүйлийг Монгол Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн захирал, доктор (Ph.D) Ц.Даваадорж, Монголын Кайзэн холбооны дэд

ОЛОН УЛС СУДЛАЛ

ерөнхийлөгч, Коннект компанийн ерөнхий захирал Ж.Хишигжаргал нар, “Японы жижиг дунд үйлдвэрийн хөгжлийн туршлага, сургамж” хэмээх II бүлгийн I, II зүйлийг доктор (Ph.D) Б.Сэржав, III зүйлийг магистр А.Сосорбурам, “Жижиг дунд үйлдвэрийн хүний нөөц ба боловсролын бодлого” хэмээх III бүлгийн I зүйлийг Б.Сэржав, М.Болормаа, А.Сосорбурам нар, II зүйлийг магистр М.Болормаа, III зүйлийг Б.Сэржав бичиж, доктор Ц.Даваадорж редакторлав.

Энэ ном манай улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг түргэтгэх, үйлдвэржилтийг хэрэгжүүлэх, ард түмний аж амьдралын түвшинг сайжруулах үйлсэд гар бие оролцогч та бүхний мэдлэгт өчүүхэн боловч тус нэмэр болно хэмээн найдаж байна.